



АРХАНГАЙ АЙМГИЙН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Аудитын код: АРА-2017/14/СТА-ТШЗ

1. Аудитын гэрчилгээ
2. Аудитын тайлан
3. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас:

Тэргүүлэх аудитор: Д.Уламбаяр

Утас: 70333141

Аудитын менежер: Т.Байгалмаа

Утас: 70332860

Ахлах аудитор: Н.Алтантуяа

Утас: 70333019

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	3
2.1	Оршил	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	3
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	7
2.9.1	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	7
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.12	Шилэн дансны мэдээлэл	8
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	9
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	9
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	10
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
3.4	АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	14
3.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	15

1 Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА

АРХАНГАЙ АЙМГИЙН

АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг

Утас/Факс: (976) 7033-3141

E-mail: arkhangai@audit.gov.mn

АРХАНГАЙ АЙМГИЙН ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Ц.ЭРДЭНЭЦОГТ ТАНАА

2017.02.23 № 73

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Шүүхийн тамгын газрын төсвийн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болсон, аккрузал сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн дагуу Архангай аймгийн Аудитын газраас аудит хийв.

Шүүхийн тамгын газрын төсвийн захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь Төсвийн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шүүхийн тамгын газрын төсвийн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан. Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт:

Шүүхийн тамгын газрын төсвийн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар журмуудын дагуу материаллаг алдаагүй үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.УЛАМБАЯР

2 Аудитын тайлан

2.1 Оршил

АРХАНГАЙ АЙМГИЙН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ Ц.ЭРДЭНЭЦОГТОД ТАНИЛЦУУЛЖ БАЙНА

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Шүүхийн тамгын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Шүүхийн тамгын газрын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017.02.13-наас 2017.02.23-ны хооронд хийж, аудитын тайланг 2017.02.24-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, хариуцаж хэрэгжүүлэв.

Шүүхийн тамгын газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа төрийн аудитын байгууллагад 2017.01.25-ны албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Шүүхийн тамгын газар нь **“Шударга ёс, хүний эрх, эрх чөлөөний баталгаа байж, шударгаар шүүх нь манай шүүхий эрхэм зорилго мөн”** гэж тодорхойлсон бөгөөд ШЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд Энэ эрхэм зорилгоо хэрэгжүүлэх үүднээс тус тамгын газар нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах ажлыг нэгтгэн зохион байгуулах Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн чиг үүргийн хүрээнд шүүхийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр ханган ажиллаж байна.

Шүүхийн тамгын газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Шүүхийн тамгын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Шүүхийн тамгын газрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах гэж үзлээ.

Шүүхийн тамгын газрын санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “aculous” программ хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Шүүхийн тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 17 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.5 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 3 асуудал эрсдэл дунд бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин дунд байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгов.

Шүүхийн тамгын газрын 2016 оны санхүүгийн байдлын нийт хөрөнгө 181.2 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 3.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар сонгох нь зохимжтой гэж үзлээ.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 3 чиглэлээр 4 эрсдэлтэй асуудалд 4 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 33 хувь буюу 1 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	0	0	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	1	2985,630.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	1	2985,630.00	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

2.9.1 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

2.9.2.1 Санхүүгийн тайланд аудит хийхэд 2985.6 мянган төгрөгийн материалыг НББ-д бөөн дүнгээр орлого авч, бөөн дүнгээр зарлага гаргасан зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д **"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"** гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Аудитын газраас алдаа зөрчлийн таслан зогсоох, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүллээ.

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Цалингийн зардлын дансны бичилт, тооцоог нягтлан шалгана.

2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Шүүхийн тамгын газар өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 901.2 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	901,204,900.00	869,528,558.74	96.49	31,676,341.26
1.1	Урсгал зардал	901,204,900.00	869,528,558.74	96.49	31,676,341.26
1.2	Хөрөнгийн зардал	0	0	0.0%	0.0
2	Зардлыг сахуужүүлэх эх үүсвэр	901,204,900.00	869,528,558.74	96.49	31,676,341.26

Архангай аймгийн Шүүхийн тамгын газрын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.1	Улсын төсвөөс санхүүжих	901,204,900.00	869,528,558.74	96.49	31,676,341.26
-----	-------------------------	----------------	----------------	-------	---------------

Төсөвт зардлын гүйцэтгэл 96.5 хувь байгаа нь цалин, НДШ 26.2 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардал 5.1 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт 3.6 сая төгрөгийг авч урсгал зардалд зарцуулсан байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Шүүхийн тамгын газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Тус байгууллагын 2016 оны шилэн дансны мэдээллийг шалгахад хуульд мэдээлэхээр заасан мэдээллүүдийг бүрэн оруулсан байна.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт хангалтгүй байгаа бөгөөд аудитын явцад шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр биелэлтийн талаарх мэдээллийг дахин нягталсан болно.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Шүүхийн тамгын газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Шүүхийн тамгын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

ДАНС	БАЛАНСЫН ЗҮЙЛ	төгрөгөөр	
		эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,637,035.00	9,676,215.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6,637,035.00	9,676,215.00
354	Хангамжийн материал	6,637,035.00	9,676,215.00
35410	Бичиг хэргийн материал	70,000.00	411,500.00
35420	Аж ахуйн материал	6,567,035.00	8,565,875.00
35440	Түлш шатах тослох материал	-	623,840.00
35450	Барилгын засварын материал	-	75,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	194,213,399.92	171,494,554.62
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	194,213,399.92	171,494,554.62
392	Биет хөрөнгө	193,883,400.00	171,274,554.74
39201	Барилга, байгууламж	59,365,900.00	59,365,900.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(33,126,655.94)	(34,164,830.90)
39203	Авто тээврийн хэрэгсэл	96,210,000.00	96,210,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(45,543,333.44)	(58,210,000.16)
39205	Машин, тоног төхөөрөмж	132,229,826.30	148,128,143.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(54,912,363.32)	(82,698,985.28)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	67,275,102.00	78,290,649.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(27,615,075.60)	(35,646,321.42)
393	Биет бус хөрөнгө	329,999.92	219,999.88
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хасагдуулга	(220,000.08)	(330,000.12)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	200,850,434.92	181,170,769.62
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	2,617,468.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,617,468.00	-
413	Өглөг	2,617,468.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,617,468.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	198,232,966.92	181,170,769.62
51	Засгийн газрын хувь оролцоо	198,232,966.92	181,170,769.62
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	126,635,859.67	126,635,859.67
51101	Өмч: -Төрийн өмч	126,635,859.67	126,635,859.67
512	Хуримтлагдсан үр дүн	38,594,526.30	21,532,329.00
51210	Өмнөх үеийн үр дүн	38,594,526.30	38,594,526.30
51220	Тайлант үеийн үр дүн	-	(17,062,197.30)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	33,002,580.95	33,002,580.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	200,850,434.92	181,170,769.62

3.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	төгрөгөөр	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	822,007,877.00	933,758,864.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,416,800.00	29,618,764.20
120	Нийтлэг татварын бус орлого	2,416,800.00	29,618,764.20
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,416,800.00	29,618,764.20
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	573,800.00	363,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,843,000.00	29,255,264.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	819,591,077.00	904,140,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	819,591,077.00	900,540,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	783,834,030.00	900,540,100.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	35,757,047.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	3,600,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	-	3,600,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	839,661,977.34	950,821,061.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	789,713,541.34	916,417,020.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	789,713,541.34	916,417,020.24
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	576,491,091.00	701,403,328.74
210101	Цалин	506,533,486.00	676,785,975.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	51,114,000.00	13,893,000.00
210104	Урамшуулал	18,843,605.00	10,724,353.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,630,778.00	70,180,015.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	39,219,586.00	44,660,009.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,482,239.00	5,104,001.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	5,602,798.00	6,380,001.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,120,559.00	1,276,001.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	11,205,596.00	12,760,003.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,498,331.00	39,086,327.00
210301	Гэрэл цахилгааны зардал	4,245,125.00	4,580,565.00
210302	Түлш, халаалтын зардал	31,170,811.00	31,360,681.00
210303	Цэвэр, бохир усны зардал	1,082,395.00	1,645,081.00
210304	Байрны түрээс	-	1,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,430,150.87	39,167,690.00
210401	Бичиг хэргийн материал	11,372,694.87	13,866,160.00
210402	Тээвэр, шатахууны зардал	11,665,460.00	12,151,150.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	11,793,080.00	10,032,739.00

Архангай аймгийн Шүүхийн тамгын газрын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210404	Ном, хэвлэлийн зардал	51,000.00	-
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	112,500.00	180,000.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	2,435,416.00	2,937,641.00
2105	Нормативт зардал	2,792,500.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,792,500.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,172,350.00	7,755,900.00
210601	Багаж хэрэгсэл	2,335,750.00	44,000.00
210604	Урсгал засвар	17,836,600.00	7,711,900.00
2107	Томилолт, зочны зардал	5,027,500.00	5,290,600.00
210702	Дотоод томилолтын зардал	5,027,500.00	5,290,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	3,364,605.00	2,641,950.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,213,605.00	1,351,100.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	-	654,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	150,900.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	99,000.00	433,500.00
210807	Газрын төлбөр	52,000.00	52,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,306,235.47	50,891,209.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	350,000.00	-
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	804,100.00	1,258,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	45,152,135.47	49,632,709.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,948,436.00	34,404,041.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,878,000.00	3,029,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	3,029,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	5,878,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	44,070,436.00	31,375,041.26
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,070,436.00	31,375,041.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(17,654,100.34)	(17,062,197.30)
7	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(17,654,100.34)	(17,062,197.30)

Архангай аймгийн Шүүхийн тамгын газрын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	төгрөгөөр	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	792,415,981.00	914,988,334.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	573,800.00	363,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	573,800.00	363,500.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	573,800.00	363,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	573,800.00	363,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	791,842,181.00	914,624,834.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	783,834,030.00	900,540,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	783,834,030.00	900,540,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	3,600,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	-	3,600,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	8,008,151.00	10,484,734.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	8,008,151.00	10,484,734.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	788,850,981.00	914,211,334.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	788,850,981.00	914,211,334.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	738,902,545.00	869,322,558.74
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	580,899,242.00	701,403,328.74
210101	Үндсэн цалин	561,190,161.00	667,412,843.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,654,481.00	13,893,000.00
210104	Үр дүнгийн урамшуулал	3,054,600.00	20,097,485.00
2102	Ажил олгохоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	61,630,778.00	70,180,015.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	39,219,586.00	44,660,009.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,482,239.00	5,104,001.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	5,602,798.00	6,380,001.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,120,559.00	1,276,001.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	11,205,596.00	12,760,003.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	36,138,820.00	41,703,795.00
210301	Гэрэл цахилгааны зардал	2,911,182.00	5,039,480.00
210302	Түлш, халаалтын зардал	31,560,703.00	33,390,434.00
210303	Цэвэр, бохир усны зардал	1,666,935.00	1,773,881.00
210304	Байрны түрээс	-	1,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,350,800.00	37,325,200.00
210401	Бичиг хэрэг	9,327,041.00	11,151,320.00
210402	Тээвэр, шатахуун	9,370,460.00	12,774,990.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,762,741.00	10,035,159.00
210404	Ном, хэвлэл	222,700.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	112,500.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,555,358.00	3,183,731.00
2105	Нормативт зардал	400,000.00	400,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	400,000.00	400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,982,900.00	8,823,000.00
210601	Багаж техник хэрэгсэл	40,000.00	1,595,000.00
210604	Урсгал засвар	13,942,900.00	7,228,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,637,500.00	5,290,600.00
210701	Дотоод албан томилолт	6,637,500.00	5,290,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,364,605.00	2,796,950.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	3,194,005.00	1,351,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	19,600.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	654,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	150,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	28,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	99,000.00	560,000.00
210807	Газрын төлбөр	52,000.00	52,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,497,900.00	1,399,670.00

Архангай аймгийн Шүүхийн тамгын газрын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	640,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	857,900.00	1,399,670.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,948,436.00	44,888,775.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,878,000.00	13,513,734.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	292,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	3,029,000.00
213208	Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж	-	10,484,734.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	5,586,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	44,070,436.00	31,375,041.26
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,070,436.00	31,375,041.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,565,000.00	777,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,565,000.00	777,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,565,000.00	777,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,565,000.00	777,000.00
225102	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал /ТӨҮГ/	3,565,000.00	777,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(3,565,000.00)	(777,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

Архангай аймгийн Шүүхийн тамгын газрын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.4 АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2015 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
C04	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-
C05	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	-	-
C08	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	-	-
D01	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	126,635,859.67	33,002,580.95	38,594,526.30	198,232,966.92
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	126,635,859.67	33,002,580.95	38,594,526.30	198,232,966.92
D04	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-
D05	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	(17,062,197.30)	(17,062,197.30)
D09	2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	126,635,859.67	33,002,580.95	21,532,329.00	181,170,769.62

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	төгрөгөөр	
				Дүн	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	901,204,900.00	869,528,558.74	31,676,341.26	96.49
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	901,204,900.00	869,528,558.74	31,676,341.26	96.49
210	Бараа, үйлчилгээний зардал	898,175,900.00	866,499,558.74	31,676,341.26	96.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	718,762,100.00	701,403,328.74	17,358,771.26	97.58
210101	Үндсэн цалин	680,304,700.00	667,412,843.74	12,891,856.26	98.10
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	20,966,000.00	13,893,000.00	7,073,000.00	66.26
210104	Урамшуулал	17,491,400.00	20,097,485.00	(2,606,085.00)	114.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,063,700.00	70,180,015.00	8,883,685.00	88.76
210201	Тэтгэврийн даатгал	50,313,300.00	44,660,009.00	5,653,291.00	88.76
210202	Тэтгэмжийн даатгал	5,750,100.00	5,104,001.00	646,099.00	88.76
210203	ҮОМШӨ ний даатгал	7,187,600.00	6,380,001.00	807,599.00	88.76
210204	Ажилгүйдлийн даатгал	1,437,500.00	1,276,001.00	161,499.00	88.77
210205	Эрүүл мэндийн даатгал	14,375,200.00	12,760,003.00	1,615,197.00	88.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,813,200.00	41,703,795.00	5,109,405.00	89.09
210301	Гэрэл цахилгаан	4,895,200.00	5,039,480.00	(144,280.00)	102.95
210302	Түлш, халаалт	35,389,700.00	33,390,434.00	1,999,266.00	94.35
210303	Цэвэр, бохир ус	2,028,300.00	1,773,881.00	254,419.00	87.46
210304	Байрны түрээс	4,500,000.00	1,500,000.00	3,000,000.00	33.33
2104	Хангамж, бараа материалын зардал	36,210,000.00	36,775,200.00	(565,200.00)	101.56
210401	Бичиг хэрэг	10,152,300.00	11,151,320.00	(999,020.00)	109.84
210402	Тээвэр (шатахуун)	12,479,700.00	12,224,990.00	254,710.00	97.96
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	9,712,400.00	10,035,159.00	(322,759.00)	103.32
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	46,800.00	180,000.00	(133,200.00)	384.62
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	3,818,800.00	3,183,731.00	635,069.00	83.37
2105	Нормативт зардал	400,000.00	400,000.00	-	100.00
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	400,000.00	400,000.00	-	100.00
2106	Эд хогшил худалдан авах	8,087,000.00	7,000,000.00	1,087,000.00	86.56
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,372,000.00	2,372,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	5,715,000.00	4,628,000.00	1,087,000.00	80.98
2107	Томилолт, зочны зардал	5,290,600.00	5,290,600.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	5,290,600.00	5,290,600.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2,899,600.00	2,796,950.00	102,650.00	96.46
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,351,100.00	1,351,100.00	-	100.00

Архангай аймгийн Шүүхийн тамгын газрын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	654,500.00	654,450.00	50.00	99.99
210804	Тээврийн хэрэгслийн татвар	252,000.00	150,900.00	101,100.00	59.88
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30,000.00	28,500.00	1,500.00	95.00
210806	Мэдээллийн технологийн зардал	560,000.00	560,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	52,000.00	52,000.00	-	100.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	649,700.00	949,670.00	(299,970.00)	146.17
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	649,700.00	949,670.00	(299,970.00)	146.17
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,029,000.00	3,029,000.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,029,000.00	3,029,000.00	-	100.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	3,029,000.00	3,029,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	904,804,900.00	900,540,100.00	4,264,800.00	99.53
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	901,204,900.00	900,540,100.00	664,800.00	99.93
131001	Улсын төсвөөс санхүүжих	901,204,900.00	900,540,100.00	664,800.00	99.93
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	5	5		-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	39.00	38.00	1.00	97.44
620001	Удирдах ажилтан	5.00	5.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	24.00	23.00	1.00	95.83
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00	-	100.00